

**“УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭС”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР, ЗААХ АРГА ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ**

Д.ОЮУНЧИМЭГ

*Ахлах багш, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхим*

Түлхүүр үг: Дээд боловсролын тухай философи хандлагууд. Бүтээлч сэтгэлгээ. Бүтээлч сэтгэлгээний арга, аргачлал. Хичээлийн хөтөлбөр, агуулга, үе шат, үнэлгээ. Хамтран суралцах нь: бүтээлчээр сэтгэгч уншигч. иш үндэслэлтэй бичигч, үндэслэл нотолгоотой, оновчтой шийдвэр гаргагчийг төлөвшүүлдэг.

Abstract: Currently, the curriculum reform is taking place intensely at the National University of Mongolia. This process of improving curriculum demands a comprehensive set of work on effectively introducing critical thinking methods in teaching and curriculum development, improving teacher-students' involvement in teaching process and rationalizing students' assessment. The pragmatic theory of learning, critical thinking, its importance and methodology of creating the skill are mentioned in the article.

Бүтээлч сэтгэлгээний философи: Суралцахын прагматик онол, түүний хүрээнд үүссэн бүтээлч сэтгэлгээ (critical thinking)-ний талаар ярихын өмнө уг онолыг үндэслэгчдийн, тухайлбал Пийрс (Piaget), Джемс (James) нарын үзэл баримтлалыг эргэн харах нь зүйтэй болов уу. Тэдний нэн тэргүүнд дэвшүүлсэн санаа бол “Суралцах бол үнэн” гэсэн томъёолол байв. Олон философичид прагматизм бол суралцахын болон үнэний холбоос руу чиглэгддэг. Ингэхдээ мэдлэгийн энгийн зарчмыг буюу холбоосыг ашигладаг болохыг тэмдэглэсэн байдаг. Хүн эхлээд сурах, мэдэх ёстой юм бол, хэрвээ мэдлэг үнэнд чиглэгддэг юм бол сурах арга зүй нь үнэн рүү чиглэгдэнэ гэсэн энгийн гаргалгааг гаргажээ.

Рационализм бол идеализмын абсолют хэлбэр. Өнөөдөр ч энэ байдлаараа оршин тогтносоор байгаагийн бодит жишээ нь хүн төрөлхтөний хэрхэн суралцахыг ойлгоход хувь нэмрээ оруулж байгаа эпистемологичид гэхэд болох бизээ. Тэд үзэхдээ мэдлэгийн өөрийнх нь онол дахь ямар ч прагматик нөлөөнөөс татгалзах гэдэгт эргэлздэг. Эпистемик гэдэг нь үнэн ба мэдлэгийн хоорондын холбоо бөгөөд мэдлэгийн онолын утга санааг агуулж байдаг. Эпистемологичид “үнэн” гэдэг бол хүн төрөлхтөний бие даан суралцах өөрийгөө хөгжүүлэх зарчимд тулгуурласан үнэний зарчим хэмээн хариулдаг бол прагматистууд хүн төрөлхтөний мэдлэгийг бүрэн дамжуулахэсвэл үнэнийг таамаглахыг гол зорилгоо болгодоггүй байна.

Рационалист философийн өөр нэг ухагдахуун нь реализм. Реалистууд хүн төрөлхтөний мэдлэгийн бие даасан байдлыг хүлээн зөвшөөрч, тэр нь дамжиж байдгийг хүлээн зөвшөөрдөг. Рационализм, прагматизмын хөгжилд нөлөө үзүүлсэн онол сургаалд Гегелийн “туйлын санаа”, Марксын материаллаг үйл явцын тухай онол, Дарвины эволюцийн онолыг тус тус нэрлэдэг бөгөөд прагматизмыг хүн төрөлхтөний суралцах үйл явц дахь хамгийн сайн санаа цуглуулж чадсан сурах үйл явц гэж хэлж болно хэмээн судлаач Пийрс (Piaget), Джемс (James) нар үзсэн байна. (Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга зүй, УБ., 2004, 8-р тал)

Хүний сэтгэлгээг, бодол санааг өөрчилж чадаж байгаа бүтээлч сэтгэлгээ гэж юу вэ? Бүтээлч сэтгэлгээ нь өөртөө маш олон чадвар, үйл ажиллагаа үнэт зүйлийг багтааж байдаг. Тухайлбал: бүтээлч сэтгэлгээ нь 1-рт Хүний оюун ухааныг хөгжүүлэх биеэ даасан чиглэл, 2-рт Бүтээлч сэтгэлгээний эхлэл цэг нь мэдээлэл, 3-рт Шийдвэрлэж болох аливаа асуудал, асуултуудаас бүтээлч сэтгэлгээ эхэлдэг, 4-рт Бүтээлч сэтгэлгээ нь зорилго бүхий нотолгоог эрж хайдаг, 5-рт Бүтээлч сэтгэлгээ нь нийгмийн шинж чанарыг хадгалж байдаг.

Бүтээлч сэтгэлгээний аргаар орж байгаа хичээл, уламжлалт аргаар орж байгаа хичээл хоёрын хооронд ямар ялгаа байна вэ? Уламжлалт хичээл “өмнөх хичээлийн талаархи тойм”, “шинэ мэдээлэл мэдлэг өгөх”, “өгсөн мэдээллээ шалгах үйл явц” гэсэн дарааллаар явагддаг бөгөөд дээрхи гурван үе шатанд багш хамгийн идэвхитэй ажиллаж, харин суралцагсад нь идэвхигүй сонсогчид болон хувирдаг. Энэ нь суралцагсдыг өнгөрсөн үеийн туршлагаар шахаж сургадаг боловч ирээдүйд гарах асуудалтай тулгарахад бэлтгэдэггүй байсан. Бүтээлч сэтгэлгээний аргаар орж байгаа хичээл нь “сэдэл төрүүлэх, сэргээн сануулах үе шат”, “утга санааг ойлгуулах үе шат”, “бататгалын үе шат” гэсэн бүтэцтэйгээр явагдаж үе шат бүрт багш, оюутны аль аль нь идэвхитэй, бүтээлчээр оролцож, сэтгэлгээ, бодол санаа, чадвар, дадлаа өөрчилж байдаг.

Дээд боловсролын тухай философи хандлагуудыг товч харьцуулж үзвэл:

	Уламжлалт буюу шинжлэх ухаан төвт	Хэрэглээ буюу систем төвт	Когнитив	Хувийн онцлогтой (туршлагын)	Социал шүүмжлэлт
Мэдлэг	Ном, баримт факт, үзэл баримтлал дахь хийгээр, онолын мэдлэг	Үйл ажилд тус болж буй мэдлэг л хэрэгтэй. Онолын болон хэрэглээний (хавсарга) мэдлэгийг хольж хутгаж болохгүй	Өөрийн бий болгосон, нөхцөл байдал, асуудлыг ойлгож тайлбарлахад туулах	Оюутнуудын эзэмшихийг хүсч буй мэдлэг, чадвар, гэдний одоогийн мэдлэг ба төгс загварын ялгааг арилгах хэрэгтэй	Түүх, нийгэм, соёлоор нөхцөлдөөн
Сурах үйл явц	Хамгийн чухал нь юу болохыг сонгоод оюутнуудад дамжуулах	Яаж суралцсан нь үр дүнгээс харагдах болно	Бодит жишээ, шинэ мэдлэгийг өмнөх туршлагатай холбох, шүүмжлэлт сэтгэлгээ	Бие биеээ хүндэтгэх, суралцах төлөвлөгөөгөө хамтран гаргах, багш бод "бүхнийг мэдэгч" биш харин туслан дэмжигч, менежер	Нийгмийн институтууд, бүлгүүдийн харилцаа, сонирхлуудыг ойлгож шүүмжлэлтэй хандах
Зорилго	Өөрийн чиглэлээр өргөн мэдлэг, судалгааны арга зүй эзэмших	Чадварлаг гүйцэтгэгч бодох	Сэтгэн бодохуйгаа хөгжүүлэх, асуудлыг таних, анализ, нотолгоо, шийдэл	Эцсийн үр дүнд хүрэх, сайжруулах арга замыг олох	Нийгмийн орчинд өөрөөр илэрхийлэх, үндэслэл нотолгоог хөгжүүлэх
Агуулга	Төсөөлсөн дүр зураг, гүн гүнзгий судалгаанаас өнгөц төсөөлөл өгөх нь чухал	Судалгаанд түшиглэсэн, ихэвчлэн практикт хэрэглэгддэг чадвар	Хязгаарлагдмал агуулга, гэхдээ нилээд гүн гүнзгий	Бэлэн зүйл биш харин чиглэл, бүтцийг өгөх нь илүүтэй	Нийгмийн тулгамдсан асуудлууд, түүний судалгаа
Үнэлгээ	Мэдлэгийн хэмжээг баримтална, оюутнуудыг эрэмбэлдэг	Тасралтгүй үнэлэх, шаашдын заавар зөвлөгөөг өгөх, оюутнуудыг эрэмбэлэхгүй	Бүрэн гүйцэд ойлгоц болон оюуны чадварыг үнэлнэ	Өөрийн үнэлгээ, өнөөгийн хүрсэн төвшин	Хамтын ажил, Төсөл
Нөөц хэрэглэгч дэхүүн	Сурах бичиг, лекцийн хэвлэмэл тэмдэглэлүүд чухал Номын сан ба анхдагч эх сурвалжуудыг ашиглах нь бага	Интерактив хэрэгслүүд, лаборатори, тусгай өрөө, танхим	Жижиг бүлгийн ажил, номын сан, судалгаа	Багшаас ганцаарчлан зөвлөгөө авах, номын сан, мэргэжлийн хэлхээ холбоо	Жижиг бүлгийн ажил Даллага ажил
Жишээ нь	Нийгмийн ухааны ихэнхи салбарууд, Түүх.	Хэл, Хөгжим	Сэтгэл судлал, Философи, Математик	Менежмент, Боловсрол судлал	Эрх зүй, Жэндэр судлал, Экологи

Ийнхүү дээд боловсролын тухай философи хандлагууд мэдлэг, сурах үйл явц, зорилго, агуулга, үнэлгээ, нөөц хэрэглэгдэхүүнээрээ эрс ялгаатай нь харгалдаж байна.

Их сургууль, коллежийн сургалтанд хэрэглэгддэг зарим нэр томъёог авч үзвэл: леки (lecture), семинар (seminar), хураангуй леки (lecturette), бүлгээр ажиллах арга (group work), төсөл (project), хослуулсан арга бүхий сургалт (gapped lecture), компьютерийн тусламжтай сургалт (C.A.L), албан бус хичээл (informal lecture), багшаар удирдуулсан сургалт (tutorial), багшийн оролцоогүй хэсэг (tutorless group), бусдаас үлгэрлэн шийдвэр гаргах (simulation), дүрээр тоглох (role play), жишээн дээр суралцах арга (casestudy), завгүй хэсэг (buzz groups), зааварчилгаа бүхий уншлага (guided reading), нээлттэй сургалт (open learning), оюуны дайралт (brainstorming), өөрсдөө асуудлыг шийдвэрлэх хэсэг (self help group), пирамид бүлэг (pyramid group), хээрийн судалгаа дадлага (field study), харилцан ярилцлагын арга (Socratic technique), тодорхой зорилгод чиглэгдсэн сургалт (task-based learning), тоглоом (game), хөдөлгөөнт хэсгүүд (gross over group), эвлүүлэх сургалт (jigsaw learning), зайны сургалт (distance learning), эргэх холбоо (feedback session) зэрэг сургалтын олон хэлбэр, нэр томъёонуудын агуулга, мөн чанарыг сайтар ойлгох нь их сургууль, коллежийн сургалтанд оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх үндэс болж өгнө.

Улмаар бид сургалтын ямар төлөвлөгөөгөөр сургалтаа явуулж байна вэ? Хичээлийн хөтөлбөрийн шинэчлэлт юуг голлон анхаарах ёстой вэ?

Хичээлийн хөтөлбөр гэдэг бол бидний заах хичээлийн бичмэл тэмдэглэл, нэрийн хуудас төдийгүй тухайн хичээлийг үнэлэх суурь баримт бичиг.

Хичээлийн хөтөлбөр нь сурах үйлийн өргөн агуулга, хүрээний дотор тухайн курс хичээлийн гүйцэтгэх үүрэг, байр суурийг тогтоох бөгөөд боловсролын зорилгын тухай багшийн итгэл үнэмшлийг тодорхойлж, заах хичээлийнх нь хөг хэмнэлийг тохируулахад тусалдаг.

Хичээлийн хөтөлбөр, багш, оюутаныхоорондын харилцааны эхлэлийг тавьж, хичээлийн логик уялдааг танилцуулж, тухайн хичээлийг судлан үзэхэд бэлэн эсэхээ шалгах боломж оюутнуудад олгодог. Мөн оюутнуудын идэвхитэй сурах үйлийг тодорхойлж ангийн ажил амжилттай хийж гүйцэтгэх үүргийг нь зааж тусгадаг бөгөөд эцэст нь хичээлийн хөтөлбөрийг сурах, сургах гэрээ гэж үзэж болно.

Хичээлийн хөтөлбөрийг боловсруулах үйл яви дараахи дарааллаар явагдана:

Хичээлийг заах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох
Оюутнуудын онцлогийг харгалзах
Агуулгыг тодорхойлох
Зорилго, зорилгоо тодорхойлох
Заах арга ба үнэлгээний аргачлалаа сонгох
Хэрэгжүүлэх, үнэлгээ өгөх

Хичээлийн хөтөлбөр боловсруулах үндсэн алхмууд:

1. Мэдээлэл цуглуулах: Үүнд “хичээлийн тухай”, “оюутнуудын тухай” мэдээлэл цуглуулна гэсэн үг бөгөөд “хичээлийн тухай” мэдээлэлд тухайн хичээлийн агуулгын хамрах хүрээ, түүнд холбоотой ном зохиол, баримт материалуудыг цуглуулах бол “оюутнуудын тухай” мэдээлэлд тэдний сэтгэн бодох үйл ажиллагааны хөгжлийн үе шатыг буюу оюуны болон ёс суртахууны хөгжлийн үе шатыг тодорхойлох, өөрөөр хэлбэл өмнө нь үзэж судалсан мэдлэг, мэдээлэл, чадвар, дадал зэргийг тодорхойлно.

Сэтгэн бодох үйл ажиллагааны хөгжлийн үе шатыг судлаач Уиллиам Перригийн “Коллежийн жилүүд дэх оюуны болон ёс суртахууны хөгжлийн хэлбэрүүд” схемээс харж болно:

Үе шатууд	Мэдлэг хэр бодит вэ?	Шинэ мэдээлэлд хэр нээлттэй вэ?	Удирлагатай ямар харилцаатай вэ?	Мэдлэг, үйлдэл хоёрын харилцаа
Хоёр туйлт	Үнэмлэхүй бодит	Хэрвээ таалагдахгүй бол хүлээж авахгүй	Дагамтгай, хүндтэмгий, гомломтгой	Илэрхий
Олон туйлт	Бодит гэдгийг мэдэхэд хэцүү	Нээлттэй, гэхдээ ялгаварладаггүй	Нөхцөл байдлаас шалтгаална	Тодорхой бус, нөхцөл байдлын хүчин зүйлээс шалтгаална
Нээлттэй, бэлэн байдал	Явз явз, шинэчлэх шаардлагатай	Нээлттэй, гэхдээ хэрэгтэй, чухлыг нь ялгаж авна	Удирлагын шаардлагыг завал үнэлж үзнэ	Аливаа юмны утгыг олох процесстэй холбоотой, шинэ мэдээллийн дагуу хуучнаа эргэж харна

2. Хичээлийн зорилго, зорилгыг зөв тодорхойлох: Суралцах гэдгийг өмнө нь бид мэдэх, мэдлэгтэй болох гэж ойлгож байсан бол өнөөдөр суралцах гэдэг мэдэх төдий бус тодорхой чадварууд олж авах, зөв дадлууд эзэмшихээр тодорхойлогддог болсон. Тэгээд ч төгсөгчдийн чанарыг хэний ямар зохиол уншиж мэдсэн бэ гэдгээр бус “ямар ямар чадвар эзэмшсэн, аливаа асуудалд хандах зөв дадал эзэмшсэн эсэхээр хэмждэг.

Хичээлийн зорилго, зорилт нь дараах гурван төсөөлөлд тулгуурлана. Үүнд: 1-рт “Боловсрол гэдэг бол оюуны сэтгэн бодохуй, мэдлэг өөрчлөгдөн хувьсах үйл явц юм” 2-рт “Хичээл эхлэхэд оюутнуудад юуг сурах шаардлагатай байгааг тодорхой мэдээлэх нь чухал” 3-рт “Оюутнууд юуг хийж гүйцэтгэнэ түүнээс нь тэдний ойлголт төсөөлөлд өөрчлөлт орох эсэх нь хамаарна” гэдэгт тулгуурлах аваас хичээлийн зорилго, зорилт оновчтой гарч ирнэ. Хичээлийн зорилгыг тодорхойлохдоо оюутны байр сууринаас харахад боловсролын зорилгын ерөнхий үндэслэл харагдахаар, зорилтуудад оюутнууд юуг үзэж судлах гэж буй тухай тодорхой үндэслэлүүд тусгагдсан байхаар тодорхойлох нь оновчтой.

Зорилго, зорилтууд нь ил болон далд аль ч хэлбэрээр үүсч болох оюутны үйл байдалуудыг тодорхойлж тусгасан байх ёстой. Тухайлбал танин мэдэхүйн когнитив зорилтууд болох мэдлэг, ойлгоц, хэрэглээ, анализ, синтез, индукц, дедукц, үнэлгээ, эффе́ктив зорилтууд болох хүлээн авах, харьцуулах, үнэлэх, зохион байгуулах, тодорхойлох, хийсвэрлэх зэргийг тусгана. Бидний заримдаа гаргадаг алдаа бол зорилго, зорилгоо тодорхойлсон үг хэллэгээ ашиглан хөтөлбөрийн сэдвүүдийг тодорхойлох тохиолдол байдаг. Жишээ нь лекцийн сэдэв: “сонгууль, сонгуулийн систем” зорилт нь “сонгууль, сонгуулийн системийн тухай мэдлэг эзэмших” гэж тодорхойлох, хэт ерөнхий тодорхой бус зорилго тавих зэрэг нь алдаа юм.

Хичээлийн зорилго оюутны эзэмших чадвар, дадлыг тусган илэрхийлдэг бол зорилт нь сургалтаас гарах үр дүнгүүдийг тодорхой гаргаж өгнө.

3. *Хичээлийн агуулгаа хэрхэн тодорхойлох:* 1-рт холбогдох ном зохиол, баримт материал, гарын авлага, нэг сэдэвт бүтээл, өөр бусад хичээлийн хөтөлбөр зэрэг олон зүйлийг судалж, цуглуулна. 2-рт энэ салбарт хичээл зааж буй гадаад лотоодын багш нараас мэдээлэл авах, сурвалжлага, санал асуулга, өгүүллэл, илтгэл зэргийг судлах. 3-рт тухайн мэргэжлийн практик туршлагын тухай мэдээлэл, тайлан, илтгэл, веб хуудас зэргийг ашиглана. 4-рт Оюутнууд болон ялангуяа төгсөгчдөөс авсан мэдээлэл, тухайн хичээлтэй холбоотой сэдвээр диплом болон ангийн ажил бичсэн чанарыг үзэж судлах зэрэг нь багшид өөрийн хичээлийн хөтөлбөрөө боловсруулах, сайжруулахад нэн чухал. Хичээлийн бүтцээ юунд түшиглэж хэрхэн томъёолох вэ? гэдгээ багш сонгоно.

Судлах зүйлийн логик уялдаагоновчтой болгохын тулд цаг хугацаа, он дараалал, учир шалтгаан, үйл ажиллагааны хүрээ зэргийг тодорхойлж улмаар хичээлийн агуулга, сэдэл төрүүлэх сэдвээ илэрхийлэх хэлбэрээ (яруу найраг, хүүрнэл зохиол, жүжиг кино, зураг, бодит үзүүлэн г.м.) сонгоно.

Хичээлийн сэдэл төрүүлэх, үндсэн агуулгаа хүргэх олон арга, аргачлал байдагч тэдгээрийг үндсэнд нь “Дүр болон чадварт түшиглэсэн”, “Төсөл ба асуудалд түшиглэсэн”, “Үндсэн ойлголтуудад түшиглэсэн когнитив бүтэц бүхий” гэсэн төрлүүдэд хуваан авч үзвэл хичээлийн бэлтгэлээ хангахад ойлгомжтой болно.

“Дүр болон чадварт түшиглэсэн” хэлбэрийг сонгон хэрэглэнэ гэдэг бол тухайн хичээлээр хөгжүүлэхийг зорьж буй чадвар, дадалтай холбогдуулж судлах зүйлээ төлөвлөнө гэсэн уг бөгөөд анализ, асуудал шийдвэрлэх, үнэлгээ өгөх, харьцуулах, мэдээлэл солилцох зэрэг олон аргуудыг хослуулан ашиглана.

“Төсөл ба асуудалд түшиглэсэн” хэлбэрийг сонгон хэрэглэж байгаа бол оюутнуудад ажлын талбар, практикт тулгарч болох нөхцөл байдал, асуудлууд, (сонгуулийн зардлыг хэрхэн багасгах вэ? Агаарын бохирдлыг хэрхэн багасгаж болох вэ? г.м.) уг асуудлын шийдлийг олоход шаардлагатай мэдлэгийг эзэмших, мэдээллүүдийг олж авахад чиглэгдэнэ.

“Үндсэн ойлголтуудад түшиглэсэн когнитив бүтэц бүхий” хэлбэрийг сонгон хэрэглэж байгаа бол тодорхой ойлголт, ухагдахуунуудын (“хувьсгал”, “эко́систем” “даяарчлал”, “эрх чөлөө” г.м.) агуулга, мөн чанарыг танин мэдэхэд чиглэгдэх бөгөөд харьцуулах, үнэлгээ өгөх, мэдээлэл солилцох анализ хийх зэрэг олон аргуудыг оновчтой хослуулан эх зохиол, сурах бичиг, баримт материал ашиглан танин мэдэхүйн эрэл хайгуул хийнэ.

Хичээлийн агуулгын үндсэн бүрдэл хэсэгт “Цөм хэсэг” (үндсэн бүрдэл хэсгүүд, хамгийн чухал хэсгүүд, эдгээргүйгээр хичээлийн агуулганэгтгэгдэж томъёологдох боломжгүй хэсгүүд), “Нийтлэг хэсгүүд” (сэдэв, гол санаа, асуудлууд, үнэлэмж зэрэг куре хичээл бүрт нийтлэг байх хэсгүүд) орох бол харин нэмэлт материалуудыг оюутны төвшин, группын онцлог зэргийг харгалзан өөр өөр сонголтоор ашиглаж болно. Тухайлбал: Сонголт 1-“Тусалцаа”: Хичээлийг үзэхэд зайлшгүй шаардлагатай суурь мэдлэггүй оюутнуудад зориулна. Сонголт 2-“Баяжуулах нь”: Зохио суурь мэдлэгтэй бөгөөд агуулгыг мэдэж буй оюутнуудад зориулна. Энэ нь нэмэлт материалууд болон үнэлгээ байна. Сонголт 3-“Сонгох нь”: Ерөнхий нэг сэдвийн хүрэн дэх үзэл санаануудаас сонголт хийх боломжийг оюутнуудад олгоно.

4. *Хичээлийн үе шат*үүд: Хичээл үндсэндээ “сэдэл төрүүлэх, сэргээн сануулах”, “утгыг ойлгуулах”, “бататгах” гэсэн 3 үе шаттай явагддаг. Харин “хичээлд бэлтгэх” үе шат бол өргөн утгаараа багш хичээлийн бус цагаар уншиж судлах, мэдээлэл цуглуулах, судалгаа хийх, хурал семинарт оролцох сургалтанд бэлтгэх зэрэг бүхий л үйл ажиллагааг хамруулан ойлгож болох бол явцуу утгаараа тухайн хичээлийг явуулах арга хэлбэрт тохируулан бэлтгэхийг хэлнэ.

“Сэдэл төрүүлэх, сэргээн сануулах үе шат”-ны онцлог ач холбогдол:

Суралцагсдад шинжлэх ухааны төсөөллийг тэдний мэддэг зүйл дээр нь тулгуурлан өгөх нь сэргээн сануулах (evocation) шатны үндсэнзорилго байдаг. Сэргээн сануулах шатны хоёр дахь том зорилго нь суралцагсдыг сурах үйл ажиллагаанд идэвхитэй оролцуулах явдал. Сэргээн сануулах шатны гурав дахь зорилго бол суралцагсдын “анхаарлыг төвлөрүүлэх” явдал. Өөрөөр хэлбэл уур уцаартай, сэтгэлээр унасан, эсвэл хэт их хөөрсөн, ядарч нойр нь хүрсэн гэх мэт сэтгэл зүйн янз бүрийн байдалтай орж ирж байгаа оюутнуудын хувийн асуудлуудыг мартуулж тухайн хичээлд татан оруулахад сэдэл төрүүлэх, сэргээн сануулах үе шат ихээхэн ач холбогдолтой юм. Тийм учраас оюутнуудын анхаарлыг нь татаж чадахуйц, хичээлийн сэдвээр сэдэл төрүүлэхүйц кейс, өгүүлэл, зураг, баримт материал, кино зэрэг материалыг багш хичээлд бүрт олж бэлтгэх нь тухайн сэдэвт оюутнуудыг бүрэн татан оролцуулдаг. Иймээс энэ нь багшийн хичээл төлөвлөлтөд оруулах чухал үе шат юм. Гэхдээ сэдэвтэй холбоотой аль тааралдсан зүйлийг хэрэглэж болохгүй. Гагцхүү тэр нь тухайн хичээлийн зорилго, зорилт, үр дүнд тохирч, хөтөлж байх шаардлагатай.

Ингээд уг үе шатны эцэст тухайн оюутнууд тус сэдвийг цааш судлах зорилгыг өөрөө өөртөө төлөвлөж чадсан байх аваас энэ шатны үүрэг үндсэндээ биелэгдлээ гэж ойлгож болно.

Сэдэл төрүүлэх, сэргээн сануулах үе шатыг 20-30 оюутантай анги танхимд хэрэгжүүлэх арга хэрэгсэл олон боловч 100-200 оюутантай поток лекц орох нөхцөлд зарим арга хэрэгслүүд хязгаарлагддаг сул талтай.

Хичээлд оролцох сэдэл төрүүлж, сонирхлыг нь татсанаар оюутнуудын анхаарлыг төвлөрүүлж, мөн өмнө нь үзэж судалсан мэдлэг, мэдээллийг нь сэргээн сануулсны үндсэн дээр шинэ хичээлээ орно. Хичээлийн сэдэл төрүүлэлт нь сэдэвтэйгээ уялдсан, асуудал дэвшүүлсэн, сонирхлыг нь татсан байх шаардлагатай.

Оюутнуудын анхаарал 15-20 мин тутамд сарниж байдаг зүй тогтлыг тооцоолсны үндсэн дээр багш 90 минутын лекцийг анхаарал татаж эхэлж, асуудал дэвшүүлэн сонирхол төрүүлж завсарлах бөгөөд үндсэн лекцийг дотор нь хэд хэдэн хэсэг болгон сэдэл төрүүлэлт, сэргээн сануулалтыг тухай бүрт нь оновчтой ашиглаж чадвал танхим бүхэлдээ 90 минутын турш багшийн хүссэнээр ажилладаг. Ийм нөхцөлд мэдлэг олгох, мэдээллүүд дээр ажиллахад хялбар, урамтай байна.

“Утга санааг ойлгуулах (*realization of meaning*) үе шат” бол хичээлийн үндсэн үе, шинэ мэдлэг бүтээх, суралцах үе шат бөгөөд хичээлийн нийт хугацааны 70-90%-ийг эзэлдэг. Энд лекц болон семинарын хичээлийг олон хэлбэрээр, бүтээлч сэтгэлгээний арга, аргачлалуудыг ашиглан явуулах нь үр дүнтэй. Сургалтын шинэ арга, хэлбэрүүд нь эхний үед төвөгтэй мэт санагдавч хэрэгжүүлж хэвшээд ирэхээр оюутанд өгөөжтэй төдийгүй багшийг цаг ямагт урагшилж, мэдлэг, мэдээлэл, ур чадвараа нэмэгдүүлж байх нөхцөлд оруулж байдаг ач холбогдолтой. Энд багш өөрийн зааж сургахыг хүссэнээ төдийгүй, суралцагсдын шаардсан, сонирхсон бүхэнд хариулт өгөх болно. Бүтээлч сэтгэлгээний аргуудыг хэрэглэснээр оюутан хичээл оролцохдоо “Би энэ талаар өмнө нь ямар мэдлэгтэй байв? Өнөөдөр юу сурч мэдэж авав? Багшаас тодруулж мэдэх, асууж сонирхох ямар асуулт байна?” гэсэн дарааллаар оролцож хичээлээс юу авч үлдэх зорилгоо мэдэж авдаг ач холбогдолтой. Бүтээлч сэтгэлгээний аргуудыг ашиглах нь багшийн зүгээс хичээлийн бэлтгэлд цаг зав нилээд үрдэг ч зарим талаараа хичээлийн үед багшийн хөдөлмөрийг хөнгөвчилж өгдөг онцлогтой.

Өнөө үед төгсөгчдийг маань ажилд авахдаа “юу мэддэг вэ?” гэж бус харин “юу чаддаг вэ?” гэж асууж ажилд авдаг. Бүтээлч сэтгэлгээний аргуудаас оюутны сургалтанд хэрэглэх нь тэд зөвхөн мэдлэгтэй төдийгүй чадвартай, зөв дадалтай мэргэжилтэн болоход тустай. Боловсрол бол мэдлэг юм гэсэн ойлголт нэгэнт үеэ өнгөрөөж, боловсролд мэдлэг төдийгүй тэрхүү мэдлэгээ хэрэглэх чадвар, зөв дадал нэн чухлыг хүлээн зөвшөөрөх болсон.

“Утга санааг ойлгуулах үе шат”-нд лекц, семинарын хичээлийн сэдэв, агуулга, суралцагсдын тоо, хичээлийн хэрэглэгдэхүүн зэрэгтээ тохируулан бүтээлч сэтгэлгээний аргуудаас сонгон авч хавсруулан хэрэглэнэ.

Бүтээлч сэтгэлгээний аргад :“Боловсронгүй лекшийн арга”,“Зэрэгцүүлсэн тэмдэглэл хийх арга”,“Эрэл хайгуул, судалгаанд чиглүүлэх арга”,“Голнэр томъёог эргэн харах арга”,“KWL хүснэгтийн арга”,“Марафон бичлэгийн арга”,“Багцлах арга”,“Сэтгэн бодож санаа бодлоо солилцох арга”,“Дотор нь орж таних арга”,“Загварчлах арга”, “Дүрд тоглох арга”, “Багийн тоглоом, тэмцээний арга”, “Шооны арга”,“Эвлүүлгийн арга”, “Будангийн арга”, “Мэтгэлцээний арга”. “Үнэлгээний цүнх” арга.“Бичих үйл явцын арга”, “Графикийн арга” (Үзэл баримтлалын хүснэгтийн арга, “Т”-хүснэгтийн арга, Веннийн диаграммын арга)“Үнэлгээний арга”. “Асуулгын арга”, “Харилцан бие биедээ хичээл заах арга” зэрэг олон аргуудыг нэрлэж болох бөгөөд эдүгээ улс орнуудын практикт өргөн хэрэглэгдэж байна. Шинжлэх ухаан технологийн хөгжлийн хурдацтай хөгжлийн өнөө үед шинэ шинэ арга, аргачлалууд практикт нэвтэрсээр байна.

Бүтээлч сэтгэлгээний эдгээр аргуудын ихэнхи нь дотроо хэд хэдэн хувилбартай. тэдгээр нь өөр өөрийн технологитойг анхаарах хэрэгтэй. Жишээ нь “Блүүмийн асуултын арга” гэхэд: “нэг хариултаг асуулт”, “урамшуулах асуулт”, “хөрвүүлэх асуулт”, “тайлбарлах асуулт”, “хэрэглээний асуулт”, “нэгтгэн дүгнэх асуулт”, “үнэлж дүгнэх асуулт” зэрэг олон хэлбэртэй бөгөөд асуултын хэлбэр бүр сэтгэн бодох аль нэг аргыг үзүүлж, тэр нь ялгаатай санаа бодолд хүргэж, эргээд илүү боловсронгуй, илүү баялаг ойлголтод хүргэнэ. Энэ бол суралцагчдыг сэтгэлгээний доод түвшнээс дээд хэлбэрт хүргэх сургалтын зорилго юм.

Хичээлийн “бататгах (*reflection*) үе шат” : Бататгах үе шатыг нэг хичээлийн туршид хэдэн удаа ч явуулж болно. Сурагчийн түвшинд энэ үе шатанд багшийн заасныг мартахгүйн тулд дахин давтах үйлдэл голлодог бол оюутны түвшинд хичээлийн үр дүнг оюутнууд хэрхэн ашиглах вэ? гэдэгт голлон чиглэгдэнэ. Энэ үе шат нь маш олон хувилбартай байж болох бөгөөд энэ нь судалж буй хичээл, оюутны мэдлэгийн түвшин, хичээлд зарцуулж буй хугацаа зэргээс хамаарна. Бататгалын аргын нэлээдийг нэг удаагийн хичээлийн үед хэрэглэдэгч заримыг нь гэрийн даалгавар хийхэд юм уу, дараачийн хичээлд дээр хэрэглэхээр үлдээж ч болно. Тухайлбал бие даах ажлыг “шүүн ярилцах буюу бичгээр хийх даалгавар”, “ур чадвараа хэрэглэх буюу үзэл баримтлалаа танилцуулах даалгавар” гэх мэтхэлбэрүүдээр өгч болно. Хамгийн чухал нь оюутан хичээлээр олж авсан мэдлэгээ бүтээлчээр ашигласнаар хичээлийн бататгал үр дүнтэй болно. Хичээлийн нэмэлт болгож танхимийн бус цагаар хийх бататгалд “сурвалжлага”, “бие даасан судалгаа”, “эссе бичих”, “зохион бичлэг”, “төсөл танилцуулах”, “үзэсгэлэн гаргах”, “хурал, тоглолт зохион байгуулах”, “зураг авах”, “санал асуулга явуулах”, “мэдээлэл цуглуулах” зэрэг олон бүтээлч аргаар хичээлийн бататгалыг хийх нь үр дүнтэй, сонирхолтой, өгөөжтэй байдаг.

“Хичээлд бэлтгэх үе шат” : Энэ бол багшаас хамгийн их цаг хугацаа, хүч хөдөлмөр шаарддаг үе шат. Хичээлд ашиглах тараах материал бичиж бэлтгэх, түүнийгээ олшруулах, үзүүлэн таниулах материалуудыг (PowerPoint...) зохих програмууд дээр бэлтгэх, унших ном зохиолын нэр, үзэж танилцах зүйлийн интернет хаягийг урьдчилж өгөх, бие даах ажил, семинарын даалгаварыг сонголттой, бүтээлчээр хийх зааварчилгааг оюутан бүрт цахим хэлбэрээр өгөх, зарим тохиолдолд лекцтэйгээ холбогдуулан унших материалыг цахимаар явуулах, семинарын групп бүрт нэгдсэн цахим мэдээллийн сан ажиллуулах (Е – сургалт), шаардлагатай гэж үзсэн тохиолдолд оюутнуудын бие даах ажлыг цахим хэлбэрээр байршуулан бие биенээр нь үнэлгээ өгүүлэх, хичээлийн хөтөлбөр, сэдэвчилсэн төлөвлөгөө боловсруулах, лекц, семинарын хичээлүүдэд бэлтгэхээрхийг явцуу утгаар багш “хичээлд бэлтгэх үе шат” гэж тооцдог. Харин өргөн утгаар дээрхи үйл ажиллагааны зэрэгцээ мэргэжлийн ном зохиол унших, хурал семинарт оролцох, судалгааны ажил хийх, сурах бичиг, гарын авлага гаргах, олон нийтийн үйл ажиллагаанд мэргэжлийн үүднээс оролцох зэрэг үйл ажиллагааг ч энэ үе шатанд хамааруулан ойлгож болно.

Хичээлийн үнэлгээ: Үнэлгээ явцуу утгаар оюутны мэдлэгийг дүгнэх хэрэгсэл бол, харин өргөн утгаар авч үзвэл дүн төдийгөөр хязгаарлагддаггүй бөгөөд сургалтын бүхий л үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг. Үнэлгээ бол хөтөлбөр хэрэгжээний дараахи тогтоогчийн үг биш харин түүний өдөр дутмын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг байх шаардлагатай. Оюутнууд үнэлгээнээс чиг баримжаа авна. Юуг хамгийн чухал гэж тооцож байгааг зааж өгдөг. Аливаа бие даах ажил, үүрэг даалгаврыг оюутнуудад өгөхдөө анхаарлыг нь хандуулж, тэдэнд нарийн тодорхой чиглэл өгөх хэрэгтэй. Үүнд: -хамгийн чухал зүйлс юу болох, зайлшгүй унших болон нэмэлт материалууд, онолын үндсийг өгөх лекц болон бусад тайлбарлах шаардлагатай зүйлс, бие даах ажлыг үнэлэх шалгуур, шалгалтын сэдвүүд, шалгалт авах арга зэргийг ил тод, тодорхой зааж өгсөн байх нь үр дүнгээ өгдөг. Үндсэн үнэлгээнд 1-рт Оюутнуудад өгсөн үүрэг даалгавар (дүнтэй болон дүнгүй), 2-рт Тэдгээр үүрэг даалгаврын биелэлтийг дүгнэх арга зам тодорхой тусгагдсан байх ёстой.

Үнэлгээ хэлбэрийн хувьд олон янз байдаг боловч хэв маягийн хувьд “Төгсгөлийн буюу улирлын эцсийн шалгалт”, “Тасралтгүй үнэлгээ буюу зөвлөн үнэлэх” гэсэн хоёр хэсэгт ялган авч үзэж болох юм. Эндээс “таны ашиглаж буй үнэлгээ хичээлд тань ямар үүрэгтэй вэ? гэсэн асуулт гарч ирж байна.

Бид яагаад үнэлэх ёстой вэ? Үнэлгээний үүрэг роль юу вэ? Оюутны хөгжлийг хангах, ахиц дэвшлийг чиглүүлэх, оюутны сонголтыг дэмжих, алдааг нь оношдох, засах боломж олгох, оюутнуудыг өдөөж идэвхижүүлэх, оюутнуудын сурах үйл, чадварын хөгжлийг хангах зэрэг үүрэг гүйцэтгэдэг төднийгүй бидний өөрсдийн ажилд өгөх үнэлгээ болдог.

Оюутнууд: тэднээс юуг хүсч хүлээж буйг мэдэж байх хэрэгтэй байдаг. Юуг хийж гүйцэтгэх ёстой, түүнийг нь хэрхэн шалгаж дүгнэх нь тодорхой байх ёстой.

Багш нар: Хичээл тавьсан зорилгодоо хүрсэн эсэх, оюутнууд үндсэн ойлголт утга санааг ойлгосон эсэх, ур чадвар нь дээшилсэн эсэх, тэд илүү дээд түвшний зүйлийг судлах, бусадтай өрсөлдөх чадвартай болсон эсэхийг харах шаардлагатай байдаг.

Сургууль институтууд: Өөрсдийн стандарт шаардлага, төгсөгчид нь мэргэжлийн ажилд тэнцэж буй байдлыг харуулах, шилдэг оюутнуудаа шагнаж урамшуулах хэрэгтэй байдаг.

Нийгэм: Их сургууль төгсөгчдөөс ямар чадвар дэдлэг хүлээж буйгаа илэрхийлэх хэрэгтэй байдаг.

Үнэлгээг үндсэнд нь “Шалгуурт тулгуурласан үнэлгээ” (хөтөлбөрийг үнэлэх буюу оюутнууд, хичээлийн стандартыг тогтоодог. Сургалтанд хэрэглэж А, В, С зэргээр дүгнэж буй хэлбэр), “Нормд тулгуурласан үнэлгээ” (Уралдаант шалгалт, шигшиж шалгаруулахад илүү ашигладаг) хэмээн ангилдаг.

Үнэлгээтэй холбогдоод дүгнэх олон хувилбарууд байх, хууран мэхлэх явдал, плагиаризмаас сэргийлэх, цээжлэн тогтоох явдалд түшиглэсэн үнэлгээнээс зайлсхийх, гүн ба өнгөц суралцахуйн алиныг нь урамшуулж байна, багшийн цаг зав, оюутны цаг завзэрэг үндсэн асуудлууд гарч ирдэг.

Үнэлгээнд тавигдах үндсэн шаардлага, шалгуур байна. Үүнд: 1. Үнэлгээ үндэслэлтэй байх ёстой. Та юуг, юуны учир үнэлэхийг хүсч байна, үнэлгээ тань хичээлийн зорилготой уялдаж буй эсэх, 2. Үнэлгээ үнэн зөв байх ёстой. Үнэлгээг нийтлэг нэг тэмдэгт, дүнгээр өгөх ёстой, 3. Үнэлгээ шударга байх ёстой. Оюутнуудад амжилттай суралцах ижил тэгш боломж олгох ёстой, 4. Үнэлгээ өдөөгч шинжтэй байх ёстой. Оюутнуудад тэд ямар түвшинд байна, цаашид юуг яаж сайжруулж болохыг хэлж өгөх ёстой, 5. Үнэлгээ цагаа олсон байх ёстой, 6. Үнэлгээ үр өгөөжтэй байх ёстой. Биелүүлж болохуйц байх ёстой, Нөгөөтэйгүүр таны болон оюутнуудын тань цаг завийг дэмий үрсэн байж болохгүй. Мөн таны үнэлгээ жинхэнэ сурах үйлийг эсхүл дүн авахад чиглэсэн сурах үйлийн алиныг нь өдөөж буйг харгалзах хэрэгтэй.

Үнэлгээгээр дамжуулан оюутнуудыг амжилттай суралцахад нь бэлтгэхийн тулд үнэлгээг ойлгоход нь туслах, үнэлгээний шалгуурыг тодорхой танилцуулах, практик хийх боломж олгох, өөрсдийн арга барилыг үнэлэх боломж олгох, хичээлд бэлтгэхдээ бие биедээ харилцан туслахыг дэмжих, цагаа зөв төлөвлөхөд нь туслах, нээлттэй байх зэргээр дэмжин ажиллана.

Багш нар өөрийн ашигладаг үнэлгээний аргуудтай байхаас гадна нэг ижил аргыг хэрэглэж байгаа багш нарын аргачлал, технологи ялгаатай байх нь олонтой.

Үнэлгээний стратеги нь үнэлгээ бүрт заавал туссан байх шаардлагатай зүйлс болох: “үнэлэх арга”, “үнэлэх шалгуур”, “ахиц дэвшил”(feedback) –эрт тодорхойлогдоно.

Үнэлгээний хэв маяг, хэлбэрүүдийн аль нь илүү оновчтой вэ?

А.-Төгсгөлийн буюу улирлын эцсийн үнэлгээ”-нд: “тест”, “аман шалгалт”, “уламжлалт бичгийн ажил”, “нээлттэй ном” шалгалт, “сэтгэн бодох” шалгалт, “гэртээ бэлдэх” буюу нээлттэй шалгалт зэрэг хэлбэрүүдийг голчлон ашигладаг. Үнэлгээний эдгээр хэлбэрүүд бүгд эерэг, сөрөг талтай. Жишээ нь:

Тест: Тестийг “олон сонголтог”, “худал ба үнэн”, “богино хариулт шаардсан” (нөхөх) гэх зэргээр олон янзаар хийж болно. Тестийн эерэг тал нь мэдлэг, ойлгоцыг шалгахад үр дүнтэй, өргөн хүрээтэй сэдвүүдийг хамарч чаддаг, дүгнэхэд ам архан бөгөөд хялбар, үнэн зөвийн магадлал өндөр бол сөрөг тал нь үндэслэл нотолгоо гаргах чадварыг үнэлж чадахгүй буюу сэтгэн болдохуйн жинхэнэ үйлийг харуулж чадахгүй, боловсруулж, тараахад зардал ихтэй, хууран мэхлэх, тааж хариулах зэрэг сул талтай.

Аман шалгалт: Тухайн хичээлийн үндсэн зорилгын нэг нь харилцааны чадвар бол аман шалгалтын эерэг тал нь оюутан бүртэй харилцах, нэмэлт асуулт асуух, ярих чадвар, ойлгоц, харилцааны чадвар, түргэн сэтгэж, асуудалд дүн шинжилгээ хийх чадварыг үнэлэх боломжтой, сөрөг тал нь цээжлэн тогтоох, цаг их зарцуулах, дүнг тайлбарлах хийгээд бичгийн чадварын үнэлгээ байхгүй зэрэг сул талтай.

Уламжлалт бичгийн ажил: нь нарийн тодорхой бүтэцтэй, асуултын сонголттой, оюутан мэдэж буй зүйлээ бичих цаг, боломжоор хангагддаг зэрэг эерэг талтай бол сөрөг тал нь хичээлийн агуулгыг бүрэн хамардаггүй, хүн бүр бичих шалгалтанд сайн байдаггүй, оюутны ахицыг харуулах нь тун бага, сурах сонирхлыг нь дэмжиж чаддаггүй, нэмэлт асуулт асууж чадахгүй, бодит амьдралтай холбоогүй,

дараагийн шатны сургалттай холбоо уялдаагүй, хууран мэхлэх боломж агуулж байдаг зэрэг сул талтай.

"Нээлттэй ном" шалгалт: Энэ шалгалтын үед оюутнуудад сурах бичиг ашиглахыг зөвшөөрдөг. Энэ нь оюутан "юуг санаж байна" гэдэгт бус харин өөрийн судалсан материалаа хэрхэн хэрэглэж чадах вэ? гэдэгт анхаарна гэсэн үг юм. Энэ тохиолдолд анализ хийх явдал маш чухал. Гэхдээ хичээлийн тодорхой нэгэн хэсгийг сонгон авч бичих оюутны сонголт хэвээр байна. Номноос зөв харнултыг олуулахад чиглэхгүй, харин асуудлын шийдлийг олох, мэдлэгээ хэрэглэх, тайлбарлах чадварыг шалгах зорилготой юм.

"Сэтгэн бодох" шалгалтыг оюутнуудын дунд нэг ерөнхий сэдэв өгч хариултыг бичүүлэх замаар авна. Өөрөөр хэлбэл оюутнууд нэг томоохон эссе бичнэ. Үүнд 3 цагийн хугацаа өгч болно. Энэ нь тэд 1 цаг орчим бодож тунгаах, тэмдэглэх, эссений бүтцээ боловсруулах хэрэгтэй ба үлдсэн 2 цагт нь бичнэ гэсэн үг юм. Шалгалтын ийм хэлбэр нь хичээлийн бүрдэл хэсгүүдийг нэгтгэх, оюутан өөрийн "толгойг" ажиллуулах, дүн шинжилгээ хийх чадварыг ашиглах боломж олгодог.

"Гэртээ бэлдэх" буюу нээлттэй шалгалт: Оюутнуудад асуулт бүхий шалгалтын хуудсыг шалгалт өгөхөөс өмнө үзүүлэх, эсвэл тэдэнд өгч гэртээ хийж ирэх даалгавар өгдөг. Шалгалтаас ихэвчлэн 2 өдрийн өмнө тэдэнд даалгаврыг өгсөн байдаг. Уг шалгалтын эерэг тал нь аз тохиох боломжгүй, айдас бага ч өндөр чанар шаардана, судалгаа хийх, нөөц хэрэглэгдэхүүнийг ашиглах, бичих зэрэг чадварыг шалгадаг. Харин сөрөг тал нь бусад хичээл болон шалгалтыг тасалдуулах, багшийг хуурах, бусдын санааг хулгайлах магадлалыг өсгөх боломжтой.

Б. "Тасралтгүй үнэлгээ буюу зөвлөн үнэлэх үнэлгээ"-нд "Эссе", "Дүрд тоглох эссе", "Бүтээлийн сан", "Хичээлийн оролцоо", "Бүлгийн хамтарсан төсөл" зэрэг үнэлгээний хэлбэрүүдийг ашиглаж байна. Үнэлгээний эдгээр хэлбэрүүд ч гэсэн мөн зэрэг, сөрөг талуудтай. Жишээ нь

"Эссе": Эссе нь сэтгэн бодохуйн өндөр чадвар, оюун сэтгэлгээний цогц дадлыг шалгадаг, үндэслэл гаргах, баримтаар нотлох, судалгаа ба нэгтгэн дүгнэлтийг шаарддаг. Түүний эерэг тал нь аналитик чадварыг заавал ашиглах болдог, оюутан өөрийн чадвараа харуулах боломжтой байдаг бол харин сөрөг тал нь плагиаризм, дүгнэхэд цаг их зарцуулдаг, хэрэв эссений бичлэгийн стандарт, тавигдах шаардлага зэргийг нарийвчилж заавар өгөхгүй бол академик бус шинжтэй уран сайхны өгүүлэл, бодомж бичих хандлага хааяа гардаг.

"Дүрд тоглох эссе": Эерэг, сөрөг талын хувьд эссетэй адил боловч үнэлгээний энэ хэлбэр өөрийн оңцлогтой. Ажил үүргийн хамаарлыг олж харах, түүнийг сонирхоход туслана. Бичилт нь илүү сайн бөгөөд бодитой болно. Асуудлын тухай оюутны хандлагыг өөрчилж болно. Жишээ нь Боловсролын сайдад хандан манай улсад хэтэрхий олон тооны дээд сургуулиуд байгааг шүүмжилж захиа бичнэ үү. Ингэхдээ Засгийн газрын тайлан баримтад түшиглэн эдийн засгийн нотолгоо гаргана уу гэх зэргээр дэвшүүлсэн асуудалд тодорхой нэг дүрийн үүднээс үндэслэл, баримт нотолгоотой хандан бичнэ. Шийдвэр гаргахдаа харгалзан тооцох хүчин зүйлсийг системтэйгээр авч үзнэ.

"Бүтээлийн сан" Оюутны хийж гүйцэтгэсэн ажлуудын цуглуулга (файл хэлбэрээр, эсвэл "үнэлгээний цүнх" ажиллуулж биет хэлбэрээр). Үүнд: эссе, шүүмж, эргэцүүлэл, дадлага ажил, төсөл, бие даах ажил гэх мэт орж болно. Анх урлаг, дизайны сургуулийн багш нар хэрэглэж байсан ба одоо "хийнгээ суралцахуй"-г дэмжин хэрэглэх болсон.

Бүтээлийн сангийн эерэг тал маш их. Тухайлбал оюутнууд хичээлтэй холбоотой ямар зүйлсийг танхимаас гадуур хийж байна вэ гэдгийг харж болно, сурах хүсэл сонирхлыг өдөөнө, оюутнууд өөрийн сурах үйл явцыг хянах боломжтой, оюутанд гарч буй ахиц дэвшлийг хөндлөнгөөс үнэлэх боломж олгоно, өөрийн үнэлгээг хийх, сурч мэдээгүй, буруу, дутуу зүйлээ сайжруулах боломж олгодог, багш оюутан бүртэй ажиллаж тусалдаг зэрэг ач холбогдолтой. Харин сөрөг тал нь багшид ямар ч үнэлгээгүй (манай өнөөгийн нөхцөлд) маш их хүч хөдөлмөр, цаг зав шаарддаг. Үнэлгээг маш нягт нямбай боловсруулсан байх ёстой, улирлын турш ингэж ажилласан нөхцөлд сул дүн авах оюутан бараг үгүй болдог талтай.

"Хичээлийн оролцоо": Хичээлийн оролцоог нь харгалзан дүн тавина. Тэд хичээлдээ суухгүй бол оролцож чадахгүй шүү дээ! Хичээлийн оролцоог ирц, идэвхээр дүгнэдэг практик манайд нэгэнт хэрэгжиж байгаа.

"Хамтарсан (бүлгийн) төсөл" –ийн давуу тал бол ганцаарчилсан жижиг төсөлд цаг заваа үрэх явдлыг зогсооно, бүлгээр хамтран ажиллах чадварыг хөгжүүлдэг, оюутанд өөрийн хийж чадах зүйлээ үзүүлэх боломж олгоно, бие биеийн ажлаас суралцах, багштай зөвлөлдөх, бусад эх сурвалжаас мэдээлэл авах боломжтой болно. Харин анхаарах тал нь оюутан бүрийн жигд оролцоог дэмжих, төслийн судалгаа, төлөвлөлт, менежмент, үр дүнг тогтмол хянаж ажиллах явдал. Шалгалтын аливаа хэлбэрүүдийн стандартыг багш (цаг сунгах, см.-р) өөрчлөөд байх юм бол үнэлгээ бодит бус болно.

Дүн бол оюутнуудыг каст-аар ангилах явдал ч биш. олимпийн уралдаан ч биш. харин сурч мэдэх хүсэл эрмэлзлэл бүхий хөдөлмөрийн үнэлгээ байх ёстой.

Яагаад бүтээлч сэтгэлгээ хэцүү вэ? 1-рт Ээдрээтэй асуудлуудын талаар бид хэрхэн боддог тухай асуулт асуух нь бидний төрмөл шинжээс харьцангуй хол. 2-рт Ихэнхи хүмүүс ихэнхи тохиолдолд урьд бий болсон, олон нийтээр хүлээн зөвшөөрсөн, удирдлага хүлээж авахуйц санаа бодол дээр үндэслэж үйлдэл хийдэг, 3-рт Бид сэтгэлгээний хэвшмэл байдалдаа сэтгэл хангалуун байгаа явдлаа өөрчлөхийн тулд, эцэст нь сэтгэж боддог аргаа өөрчлөх нь бараг л "боломжгүй" зүйл учраас бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ гэдэг хэдэн багш хичээлд суугаад эзэмших зүйл бус бөгөөд нийт сургууль, тэнхим, багш нар, сургалтын хөтөлбөр, арга, технологийг хамарсан, урт хугацааны хамтын цогц үйл ажиллагаа байж үр дүнгээ өгнө.

Бүтээлч сэтгэлгээний арга, аргачлалууд олон янз төдийгүй тэдгээр нь байнга шинэчлэгдэн баяжигдаж, мөн шинэ арга хэлбэрүүд гарч ирж байдаг онцлогтой. Сургалтанд бүтээлч сэтгэлгээний аргуудыг хэрэглэхдээ хэрэв технологийн алдаа гаргавал сөрөг үр дагавар гарах эрсдэлтэйг мартаж болохгүй. Жишээ нь мэтгэлцээний арга гэхэд "парламентын", "Линкольн-Дугласын" гэх зэрэг өөр өөр хэлбэрүүд байхад манай дунд сургуулийн багш нар мэтгэлцээний цорын ганц хэлбэр байдаг мэтээр зөвхөн "парламентын" буюу тухайн суралцагч өөрт өгсөн өгөгдлийг цаанаас оноосон үүргийн дагуу няцаах, эсвэл нотлох үүргээ л биелүүлдэг хэлбэрийг түлхүү хэрэглэж, мэтгэлцээний бусад хэлбэрүүдийг хэрэглэж сургахгүй, бараг ашиглахгүй байна. Эцэст нь сургалтын үйл явц дахь мэтгэлцээний аргын гол зорилго нь мэтгэлцэгч талаа "ялж гарахад" бус асуудлыг нөгөө талаас харж буй хэсгээсээ харилцан суралцаж, хамгийн оновчтой хувилбар руу ойртоход уг аргын утга учир оршдогийг мартаад байгаа жишээг өнөөдөр хаанаас ч харж болно.

Бүтээлч сэтгэлгээний аргуудаар хичээл орсноор оюутан өөртөө байгаа давуу талаа олж нээдэг бөгөөд улмаар сурах үйл нь хүнд хэцүү дарамт бус харин аз жаргал юм гэдгийг мэдэрч, хичээл бүрээс юу мэдэж, сурч үлдэх, цаашид мэргэжлээрээ юу хийж бүтээх вэ гэдгээ ухамсарладаг ач холбогдолтой.

Бүтээлч сэтгэлгээний арга зүйн талаар сургалт семинар явуулж ирсэн нь багш нарыг идэвхжүүлж, бидний юу заадаг болон түүнийгээ яаж заадаг талаарх төсөөллийг маань баяжуулж, урьд хийдэг байсан зүйлээ өөрөөр хийх арга, технологи олж авахад тус болж байгаа төдийгүй сургах, сурах үйл ажиллагааны талаар хийх эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг дэмжин, сургалтын арга зүй болон оюутны сурах арга барилыг өөрчлөх санал санаачлагууд гарч ирсээр байна.

Идэвхитэй болон идэвхигүй сургалтын ялгааг ихэнхи багш нар мэддэг болсон. Идэвхигүй сургалтанд учирдаг бэрхшээл гэхэд сургалт нь тодорхой цаг хугацаанд явагддаг учраас анхаарал төвлөрөх хугацаа бага, оюутнуудын сонирхол бага. "эзэн байх" сэтгэлгээ бага зэрэг дутагдлууд ажиглагддаг. Идэвхитэй сургалт явуулахын тулд сурах орчныг буй болгох, аюулгүй орчинг бүрдүүлэх нь нэн чухал бөгөөд идэвхитэй сургалтын аргуудыг хэд хэдээр нь хослуулан хэрэглэх нь үр дүнтэй.

Оюутны суралцах хандлагыг үндсэнд нь "өнгөц", "гүн" гэсэн хоёр хандлагад ялган авч үзэж болох юм. "Өнгөц" хандлагатай оюутнууд багшийн зүгээс тавигдаж буй шаардлагыг биелүүлэхийг л сонирхдог, өгч буй мэдээллээс өөр зүйлийг санаачилж сэдэхгүй, аливаа бүрэн ухаж ойлгохгүйгээр цээжлэн тогтоохыг хичээдэг, шалгалтанд, дүнд санаа зовдог бөгөөд хэрэгжүүлэх хандлага нь аль болох их мэдээллийг цуглуулах замаар өндөр оноо авахыг зорьдог. Харин суралцах "гүн" хандлагатай оюутнуудын гол сэдэл нь ойлголт авах, шинэ мэдлэг эзэмшихэд чиглэж өргөн хүрээнд уншиж, оюутнуудтай үзэл бодлоо хуваалцах, практик дээр хэрэгжүүлэх сонирхолтой, дүн авах нь гол зорилго биш байдаг бөгөөд хэрэгжүүлэх хандлага нь шалгалт авах бүхий л сэдвүүдийг судлан үздэг төдийгүй сонирхсон сэдвээр нэмэлт судалгаа хийдэг, асуудлуудыг урьдчилан таамаглахыг оролдож, сурах цагаа нягт нямбай төлөвлөж улирлын туршид өдөр дутам биеэ дайчлан ажиллалгаараа ялгардаг.

Бүх шатны сургалтын гол зорилго нь суралцагчдын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх явдал байдаг бол бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх гол зорилго нь оюутнуудыг сэтгэн бодоход сургах, сэтгэн бодох үйлдлийн хэвшмэл загвараас нь гаргаж, бүтээлчээр сэтгэх тусгай чадваруудолгох явдал юм. Сургалтын явцад суралцагчдад олон чадварууд төлөвшиж байдаг.

Сонсох, унших, ярих, бичих зэрэг чадварыг бага ангийн сурагчид ч гэсэн эзэмшсэн байтал энэ сэдвийг оюутанд ярих шаардлагатай юу? Хамгийн их шаардлагатай. Хүний эдгээр чадварууд харилцан адилгүй төдийгүй оюутан хүн өөрийн чадваруудаа байнга хөгжүүлж байх шаардлагатай. Жишээ нь "унших чадвар" гэдэгт хурдан, удаан унших, уншсанаа бүрэн зөв ойлгох, уншсанаа тогтоох гэх зэрэг олон зүйл хамаатай бол "ярих чадвар"-т уран илтгэлээс эхлээд ярианы олон төрлийг хэрхэн эзэмших тухай яригдана. "Сонсох чадвар" улс төрчид, удирдах ажилтнуудад төдийгүй хүнтэй ажилладаг бүхий л хүмүүст нэн чухал чадварт тооцогддог. Бусад чадваруудтайгаа харьцуулахад яльгүй хожуу төлөвшдөг чадвар бол "бичих чадвар", мөн "бусдад заах чадвар" юм. Тиймээс олсон мэдлэг мэдээлэл дээрээ

үндэслэлд илтгэл тавих, эрдэм шинжилгээний өгүүллэл бичих, нийтлэл гаргах, төсөл боловсруулах, сургалт явуулах, хичээл заах нь суралцагсдын ур чадварыг шинэ шатанд гаргаж өгдөг байна. Зөвхөн танхимийн хичээлээр л гэхэд “харилцан бие биедээ хичээл заах арга”-ыг багш бэлтгэлийг нь сайн хангаж, зөв технологийн дагуу явуулахын ач холбогдлыг судлаачид “Хүнд юм заана, сургана гэдэг бол сурах аргын хамгийн шилдэг нь билээ” хэмээн тэмдэглэсэн байдаг. (Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх төсөлд зориулсан зөвлөмж, II дэвтэр, 25-р тал)

Сонсох, унших, ярих, бичих гэх зэрэг чадваруудыг дээшлүүлэх арга, технологи өөр өөр, нэгэн өгүүллэгт багтаах боломжгүй юм. Үүнээс хамгийн энгийн буюу “бүтээлчээр унших чадварыг дээшлүүлэх аргачлалыг товч авч үзье: Бүтээлчээр унших гэж юу вэ?

“Унших үйл ажиллагаа нь бидэнд шинэ мэдээлэл өгөөд зогсохгүй биднээс юу уншиж байгаагаа эргэцүүлэн бодохыг шаарддаг” (Джон Локк)

Оюутнуудад тохиолддог томоохон бэрхшээлүүдийн нэг нь шинжлэх ухааны чиглэлтэй ном, эх бичвэрийг уншиж ашиглах тал дээр бүтээлчээр хандах туршлага дутмаг байдаг. Иймээс эх зохиол, ном сурах бичигтэй ажиллах зөвлөмжийг өгөх шаардлагатай тулгардаг бөгөөд уг зөвлөмжийг оюутнууд маш дуртай хүлээж авдаг.

Шинжлэх ухааны сэдэвтэй томоохон ном, эх зохиолыг хэрхэн бүтээлчээр унших вэ? Бүтээлчээр унших үйл ажиллагаа үндсэн гурван үе шат бүхий 9 алхмаас бүрдэнэ. Үүнд:

1. Унших үйл ажиллагаа: (асуулт тавих, зорилгоо оновчтой тодорхойлох)

1-р алхам: Унших зүйлтэйгээ урьдчилан танилцах

2-р алхам: Унших зүйлээ ерөнхийд нь төлөвлөх

3-р алхам: Асуулт тавих

2. Уншиж байх үеийн үйл ажиллагаа(хариулт өгөх)

4-р алхам: Унших

5-р алхам: Гол зүйлийг ялгах

6-р алхам: Хариулах

3. Уншсаны дараах үйл ажиллагаа(уншсан зүйлээ нягтлах)

7-р алхам: Уншсан зүйлээ давтан ярих

8-р алхам: Уншсан зүйлээ нягталж харах

9-р алхам: Уншсан зүйлээ бас дахин нягтлан харах

Эдгээр есөн алхам нь танд төвөгтэй мэт, ялангуяа ганц хоёрхон хуудас материал унших үед нэг их ач холбогдолгүй зүйл мэт санагдаж байж магадгүй. Гэхдээ эдгээр алхмыг бүгдийг нь нэг бүрчлэн хэрэглэх үү, сонголт хийн хослуулж хэрэглэх үү гэдэг нь унших зүйлийн хэмжээ, түвшингөөс хамаарна. Нэгэнт хэрэглээд дадсан үедээ оюутнууд.-Яагаад уншаад уншаад ойлгохгүй байсан? -Яагаад ойлгосон хэрнээ мартчихаад байсан? -Яагаад тухайн эх зохиолоос чухал зүйлийг нь олж хараагүй? -Яагаад эх зохиолыг “хэцүү” гэж боддог байсан? зэрэг асуултууддаа хариулт олж, өөрийгөө “юм ойлгодоггүй”, “юу ч тогтоодоггүй” гэж үзэхээ больж, эх зохиол, шинжлэх ухааны ном бүтээлчдээс халширхаа больдог.

Үүн лугаа сонсох, ярих, бичих, багаар ажиллах зэрэг олон чадваруудыг дээшлүүлэх арга, технологийг бүтээлчээр ашиглаж сурах нь суралцагсдад төдийгүй багш нарт ч ур чадвар нь улам л сайжирч, цаг хугацаа, хүч хөдөлмөрийг нь хэмнэж өгдөг ихээхэн ач холбогдолтой.

Бүтээлч сэтгэлгээний өсөлтийн хэмжүүр юу вэ? Энгийнээр авч үзвэл:

1. Хувь сэтгэлгээнээс нийгэмшсэн сэтгэлгээнд

2. Хөндлөнгийн хамааралт сэтгэлгээнээс бие даасан сэтгэлгээнд

3. Санамсраггүй сэтгэлгээнээс логик сэтгэлгээнд

4. Ганц хувилбарт сэтгэлгээнээс олон хувилбарт сэтгэлгээнд шилжиж чадсан эсэх юм.

Сургалтын чанар багшаас шалтгаалах уу? Оюутнаас шалтгаалах уу?

Сургах хийгээд сурах үйл ажиллагааг салгаж болохгүй бөгөөд харилцан хамааралтай болох нь ялангуяа их, дээд сургуулийн сургалт дээр илүү тод харагддаг

Сургалтын чанар багшаас үндсэндээ шалтгаална. Багшбүхэн оюутнуудаа хичээлд анхааралтай, идэвхитэй оролцож, заасан хичээлийг маань сайн ойлгож, сурч мэдсэнээ мартажгүй байж, ажил амьдрал дээр хэрэгжүүлээсэй гэж хүсдэг.

Ямар ч үед өөдрөг байх нь суралцагсдад эерэгээр нөлөөлдөг байна. “Гайхамшигтай” гэдэг үгийг дандаа хэрэглэдэг нэгэн багш амжилтанд хүрсэн жишээ байдаг бол яг үүний эсрэгээр “та нарыо ч уншдаггүй”, “та нар юу ч чадахгүй байна”, “та нарын толгой хүрэхгүй гэх мэт мессежийг үг болон үйлдлээрээ өгөөд байвал ямар ч оюутныг муу болгох, хичээлээ уйтгартай болгох, хичээлээрээ айлгах, хичээлээс нь хөндийрүүлэх тун амархан.

Сайн багш гэж хэнийг хэлэх вэ? Өөрийн зааж буй мэргэжилдээ эзэн болсон, сурч мэдэхийг хүсэж буй оюутанд туслахад ямагт бэлэн, ур чадвар, хүн чанарын хувьд итгэлтэй багшийг сайн багш гэнэ. Явцуу утгаараа танхимийн хичээлийн 90 минутын турш оюутнуудаа сайн ажиллуулж буй багшийг сайн багш гэнэ. Багшийн имижи буюу нэр хүнд, ялгарал түүний ажлын арга барилаар тодорхойлогдон үнэлэгдэж, дурсагдаж, үлгэр жишээ болж байдаг.

Хичээл бүрт баримталж байх алтан дүрмүүдийг багш мэддэг байх нь хангалтгүй бөгөөд хэвшсэн байж гэмээнэ сая үр дүнгээ өгнө.

Сургалтын үйл ажиллагаанд оролцогч хоёрдогч тал бол оюутан. Сайн оюутан, муу оюутан гэж хэнийг хэлэх вэ? Тэд хаанаас гарч ирдэг вэ?

Уг чанараасаа “сайн”, “муу” оюутнууд гэж байдаггүй. Гагцхүү сурч мэдэх хүсэл эрмэлзлэлтэй, эсвэл хүсэл эрмэлзлэл нь сэргээгүй гэсэн хоёр хэсэгт хувааж болох бөгөөд эхний буюу сурч мэдэх хүсэл эрмэлзлэлтэй оюутнууд илт давамгай байдаг. Гэтэл энэхүү сурч мэдэх хүсэл эрмэлзлэлтэй хэсгийн оюутнуудаас ч гэсэн онц сурч, амжилт үзүүлж чадахгүй байх явдал цөөнгүй тохиолддог. Үүний учир шалтгаан юу вэ? Энэ нь тэдгээр оюутнууд сурах, суралцах арга барилаа олохгүй байгаад л оршиж байна.

Оюутан гэдэг, багш нар өөр өөрийн өгөх гэсэнэ юүлж хийдэг, ямар нэг юмаар дүүргэдэг сав биш, Хэрэв тэгэж болдогсон бол өнөөдөр англи хэлний багшийн чадварыг, маргааш матаематикийн багшийн чадварыг хийж дүүргээд тун ч амархан байхсан.

Хичээл бүр дээр оюутнуудыг тодорхой дүр, үүрэг роль өгч хичээлийг явуулах нь үр дүнтэй, үлдэгтэй байдаг. Жишээ нь “Та одоо ерөнхий сайд. Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэе гэж бодож байна? Яагаад? “Та өнөөдөр гэсэн товч ярилцлагын дараа лекцийг идэвхитэй, анхааралтай сонсож, хичээлийн төгсгөлд дахин ярилцахыг хүсдэг.

Шавь төвтэй сургалтыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх нь оюутнууд төгсөөд ажиллах чадвар, дадалтай болох ач холбогдолтойг бодолцон багш “ардын жүжигчин”, оюутнууд үзэгчид байдаг хэлбэрээс харьцангуй татгалзаж байна.

Бүтээлч сэтгэлгээ нь хөгжөөгүй хүнээс аль ч салбарт очлоо ч хүссэн үр дүн гаргах боломж харьцангуй хоме байдаг байна. Иймээс мэргэжлээрээ хаана ч ажиллах чадвартай бүтээлч сэтгэлгээтэй мэргэжилтнүүдийг өнөөгийн цаг үе биднээс шаардаж байна.

Бүх шатны сургалтын гол зорилго нь суралцагсдын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх явдал байдаг бол бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх гол зорилго нь оюутнуудыг сэтгэн бодоход сургах, сэтгэн бодох үйлдлийн хэвшмэл загвараас нь гаргаж, бүтээлчээр сэтгэхэд хэрэгтэй чадваруудыг олгох явдал юм.

Бүтээлч сэтгэлгээний аргуудыг ашиглан хичээл ороход багшийн роль буурахгүй, харин ч эхэсч, мэдлэг, чадварын “дуэльд” дуудагдаж, дуудаж эхэлдэг. Сургалтын бүтээлч сэтгэлгээний хэлбэр нь эрдэмтэн багш нараас илүү их мэдлэг, мэдээллийг шаарддаг, багш оюутанд өөрийн хүссэнээ заагаад зогсохгүй мөн тэдний асууж сонирхсон, сурч мэдэхийг хүсэх бүрт зөвлөж туслахын тулд тасралтгүй хөгжиж байдаг нь түүний бас нэгэн онцлог юм.

НОМ ЗҮЙ

1. Алтанцэцэг, Т. Амарсанаа, Д. Сэтгэн бодохуйд сургах нь, МННХ, УБ., 2003.
2. Батсүх, С. Отгонсүрэн, Д. Сурах арга барилд сургах нь Бүтэжичир уншигч-1, УБ., 2002.
3. Д.Н.Богоявленский “Формирование примеров умственной работы как путь развития мышления и активизаций учения вопросы психологии”. 1982.
4. Ийстердей Мэтью, Шүүмжлэлт сэтгэлгээ, Орч. Гэрэлмаа, А, УБ., 2003.
5. Жанни Л. Стееле, Куртис С. Мередит, Чарлс Темпл. “Сургалтын агуулгыг бүтээлч сэтгэлгээгээр хөгжүүлэх замаар хэрэгжүүлэх арга зам” Зөвлөмж-1, УБ., 2002.
6. М.В.Кларин “Развитий педагогической технологий, проблема теорий обучеХйжши
7. Монгол улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, УБ., 2006.
8. Оюунцэцэг, Д. Батсүх, С. Оюунцэцэг, Ж. Амаржаргал, Т. Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга зүй, МННХ, УБ., 2002.
9. Сургууль соёлын хөгжлийн шинэ чиг хандлага, УБ., 2002.
10. Тест зохиох, түүний чанарыг шалгах. Боловсрол судлалын үндэсний хүрээлэнгийн хэвлэл, УБ., 1996.
11. “What is critical thinking” readings on critical thinking for Teachers Edited by David J.Klooster and Alison Preece. 2000.
12. Thinking classroom What is critical thinking? 2001.